

ТӨГСӨГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИД ТУЛГУУРЛАСАН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГАА

AN EVALUATION OF HIGHER EDUCATION QUALITY BASED ON GRADUATE SATISFACTION

Р.Тэргүүнцэцэг

Орхон Их Сургуулийн докторант

Terguuntsetseg R.

Ph.D student at Orkhon University, Mongolia.

Хураангуй. Бидний судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын их, дээд сургуулиудын сургалтын чанарт нөлөөлж буй нөлөөллийг шинжлэхийг зорьсон. Судалгаанд хувийн их дээд сургуулиудын төгсөгчид оролцсон ба тэдний үнэлгээг харьцуулж, цаашид хэрхэн сайжруулах боломж байгааг эрэлхийлсэн. Судалгаанд SMART PLS-3.0 программ ашиглан өгөгдлийг боловсруулж, үр дүнг тооцоолон гаргасан.

Abstract. The purpose of our study is to examine the factors influencing the education quality of universities and higher education institutions in Mongolia. Graduates from private universities participated in the study, and their evaluations were compared to explore possible ways for further improvement. The data were analyzed using the SMART PLS 3.0 software, and the results were calculated and interpreted accordingly.

Түлхүүр үгс: дээд боловсрол, төгсөгчдийн үнэлгээ, сургалтын чанар

Keywords: higher education, graduate evaluation, education quality

Нэг. Танилцуулга

Монгол Улсад дээд боловсролын сургалтын чанар, төгсөгчдийн өрсөлдөх чадвар, хөдөлмөрийн зах зээлд нийцэх байдалд бодит сорилт бий болсоор байна. Төгсөгчид нь сургалтын бодит үр дүнг хөдөлмөрийн зах зээл дээр туршин, олсон мэдлэг, чадварынхаа ашигт байдлыг шууд мэдэрдэг тул сургалтын чанарыг үнэлэх хамгийн бодит, хараат бус эх сурвалж болдог.

Бидний судалгаа нь төгсөгчдийн үнэлгээнд үндэслэн их, дээд сургуулийн сургалтын чанарын бодит түвшнийг тодорхойлох, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийг шинжлэх, сургалтын чанарыг сайжруулах оновчтой санал, зөвлөмж боловсруулахыг зорьсон.

Хоёр. Сургалтын чанарын үнэлгээний онолын зарим асуудал

Дээд боловсролын сургалтын чанарын үнэлгээ нь боловсролын философи, удирдлага, үйлчилгээний чанар, суралцахуйн үр дүн, институтын

засаглалын огтлолцолд хөгжсөн онолын өргөн хүрээтэй салбар бөгөөд сүүлийн үед чанарыг зөвхөн шалгалтын үзүүлэлтээр бус, сургалтын үйл явц, суралцагчийн хөгжил, байгууллагын тогтолцоо, нийгмийн үр өгөөжтэй уялдуулан цогцоор нь үнэлэх хандлага давамгайлж байна.

Дээд боловсролын чанарыг үнэлэх онолын үндэс нь чанарыг байгууллагын зорилго, оюутны үр дүн, болон оролцогч талуудын хүлээлтээр тодорхойлогдох олон талт ойлголт гэж үзэх шаардлагатайг харуулдаг. Дээд боловсролын байгууллага, сургалтын чанарын талаарх сүүлийн үеийн судалгаанууд чанарыг олон хэмжээст, динамик ойлголт болохыг нийтлэгээр тодорхойлж байна.

Калам, Хоссейн нар (2020) сургалтын чанарыг багшлах үйлчилгээ, хөтөлбөр, судалгаа, дэд бүтэц, бодлого, санхүүжилт зэрэг бүрэлдэхүүнээс тогтсон цогц систем хэмээн үзэж, энэ нь оюутны сэтгэл ханамж болон байгууллагын нэр хүндэд шууд ба шууд бус нөлөөтэйг



Дэргэдүүний Сэтгэл Ханамжид Тулгуурласан Дээд Боловсролын Сургалтын Чанарын Үнэлгээний Судалгаа



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ

нотолсон (Блох К , Дегн Л, Найгаард С, Хаасе С, 2020).

Блок, Дегн, Ньюгард, Хаазе нар (2020) чанарыг институтийн орчин, бодит сургалтын практик, ойлголтуудын огтлолцоогоор тайлбарлаж, бодлого ба кампусын орчны уялдаа сул байгааг илрүүлсэн. Үүнийг Блок нар (2023) өргөжүүлж, оролцогч талуудын (багш, оюутан, удирдлага) хамтын оролцоо, мөн оюутны хэрэглээний чадвар, багшийн тасралтгүй хөгжил нь чанарын гол цөм болохыг тогтоосон (Блок К, Фүглсанг С, Главинд Ж Г, Бендтсен, 2023).

Алекс Дурдас нар (2023) чанарын баталгаажуулалтыг дижитал шилжилттэй уялдуулж, чанар нь олон оролцогчийн хүлээлтээр тодорхойлогдох уян хатан, хувьсан өөрчлөгдөх ойлголт болохыг онцолсон (Дурдас А, 2023).

Антонович Кохоутек нар, (2025) дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь уламжлалт магадлан итгэмжлэлд төвлөрсөн загвараас олон хэлбэрт, уян хатан тогтолцоонд шилжиж байгааг харуулж байна (Кохоутек Ж, Антонович Д, Коватс Г, 2025).

Рахман нар, (2024), боловсролын үйлчилгээний чанарын үндсэн хэмжээсүүд (найдвартай байдал, хариуцлага, баталгаа, үнэнч байдал, сургуулийн орчин) нь оюутны сэтгэл ханамжид эерэг, статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлдэг болохыг баталсан (Рахман М.,

2024).

Энэтхэг, Балбын их сургуулиудын жишээн дээр хөтөлбөрийн чанар болон захиргааны үйлчилгээ нь оюутны сэтгэл ханамжид харьцангуй хүчтэй нөлөөлдөг төдийгүй, оюутны автономи, чадамж, хамаарал зэрэг сэтгэлзүйн суурь хэрэгцээ нь хүлээн зөвшөөрөгдсөн чанар, нийт сэтгэл ханамжийг шууд ба дам байдлаар тодорхойлох шинэ чиг хандлага тогтож байна (Жадрич нар, 2025). Бид дээрх эрдэмтдийн үзэл баримтлалыг дэмжин судалгааны ажилдаа дараах таамаглалыг дэвшүүлсэн.

Таамаглал 1. Багшийн заах арга зүй нь сургалтын чанарт эергээр нөлөөлнө.

Таамаглал 2. Багшлах арга барил сургалтын чанарт эергээр нөлөөлнө.

Таамаглал 3. Багшийн харилцаа, хандлага нь сургалтын чанарт эергээр нөлөөлнө.


Таамаглал 4. Багшийн мэргэжлийн чадвар нь сургалтын чанарт эергээр нөлөөлнө.

Таамаглал 5. Сургуулийн орчны эерэг үнэлгээ нь сургалтын чанарт эергээр нөлөөлнө.

Таамаглал 6. Удирдлагын дэмжлэг нь сургалтын чанарт эергээр нөлөөлнө.

Таамаглал 7. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ нь сургалтын чанарт эергээр нөлөөлнө. Таамаглал 8. Оюутны идэвх, оролцоо нь сургалтын чанарт эергээр нөлөөлнө.

Загвар 01. Сургалтын чанарыг үнэлэх загвар



Гурав. Судалгааны ажлын боловсруулалт, үр дүн

Бидний судалгааны ажилд Орхон их сургуулийн 786 төгсөгч хамрагдсанаас 347 эрэгтэй ба 44.15 хувь, 439 эмэгтэй оролцогч ба 55.85 хувийн харьцаатай хамрагдсан. Бид сургалтын чанарыг үнэлэх загвартаа нийцсэн асуулга боловсруулан оюутнуудаас судалгааг авч SMART PLS-3.0 программ ашиглан дүн шинжилгээ хийсэн.

Кронбах альфа 0.70-оос, нийлмэл найдвартай байдал 0.70-оос, дундаж хэлбэлзэл нь хэмжилтийн утга 0.50-аас дээш байвал тухайн хувьсагчийг найдвартай, хүчинтэй гэж үздэг. Судалгаанд ашиглагдсан хэмжил зүйн шинжилгээний үр дүнгээс харахад бүх хувьсагчийн Кронбах альфа, нийлмэл найдвартай байдал, дундаж хэлбэлзлийн утгууд нь олон улсын судалгаанд зөвшөөрөгдсөн доод хязгаараас өндөр түвшинд байсан.

Багшийн арга зүйн хэмжил зүйн үр дүнгээс харахад, Кронбах альфа утга 0.845,

нийлмэл найдвартай байдлын тоон утга 0.885, дундаж хэлбэлзлийн тоон утга 0.565 үзүүлэлттэй байгаа нь хувьсагчид хоорондоо сайн уялдаатай, тогтвортойг харуулж байна.

Багшийн заах аргын хэмжил зүйн үр дүнгээс харахад, Кронбах альфа утга 0.895, нийлмэл найдвартай байдлын тоон утга 0.912, дундаж хэлбэлзлийн тоон утга 0.635 үзүүлэлттэй байгаа нь хувьсагчид хоорондоо сайн уялдаатай, тогтвортойг харуулж байна.

Багшийн мэргэжлийн ур чадварын хэмжил зүйн үр дүнгээс харахад, Кронбах альфа утга 0.847, нийлмэл найдвартай байдлын тоон утга 0.884, дундаж хэлбэлзлийн тоон утга 0.609 үзүүлэлттэй байгаа нь хувьсагчид хоорондоо сайн уялдаатай, тогтвортойг харуулж байна.

Багшийн харилцаа, хандлагын хэмжил зүйн үр дүнгээс харахад, Кронбах альфа утга 0.763, нийлмэл найдвартай байдлын тоон утга 0.832, дундаж хэлбэлзлийн тоон утга 0.515 үзүүлэлттэй байгаа нь хувьсагчид хоорондоо сайн



МОНГОЛЫН ИРГЭДНИЙ
ХАМГААГАХ ЯАМ



ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ

уялдаатай, тогтвортойг харуулж байна.

Оюутны оролцооны хэмжил зүйн үр дүнгээс харахад, Кронбах альфа утга 0.899, нийлмэл найдвартай байдлын тоон утга 0.921, дундаж хэлбэлзлийн тоон утга 0.625 үзүүлэлттэй байгаа нь хувьсагчид хоорондоо сайн уялдаатай, тогтвортойг харуулж байна.

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний хэмжил зүйн үр дүнгээс харахад, Кронбах альфа утга 0.928, нийлмэл найдвартай байдлын тоон утга 0.943, дундаж хэлбэлзлийн тоон утга 0.735 үзүүлэлттэй байгаа нь хувьсагчид хоорондоо сайн уялдаатай, тогтвортойг харуулж байна.

Сургуулийн орчны хэмжил зүйн үр дүнгээс харахад, Кронбах альфа утга 0.940, нийлмэл найдвартай байдлын тоон утга 0.951, дундаж хэлбэлзлийн тоон утга 0.708 үзүүлэлттэй байгаа нь хувьсагчид хоорондоо сайн уялдаатай, тогтвортойг харуулж байна.

Сургалтын чанарын хэмжил зүйн үр дүнгээс харахад, Кронбах альфа утга 0.959, нийлмэл найдвартай байдлын тоон утга 0.966, дундаж хэлбэлзлийн тоон утга 0.779 үзүүлэлттэй байгаа нь хувьсагчид


хоорондоо сайн уялдаатай, тогтвортойг харуулж байна.

Бид хэмжил зүйн шинжилгээний үр дүнгээс, Кронбах альфа хамгийн их утга нь сургалтын чанар хувьсагчид 0.959 утгатай байгаа нь бусад бүх хувьсагчаас хамгийн өндөр дотоод уялдаа, найдвартай байдлыг хангаж байгааг, сургуулийн орчин 0.940, сургалтын хөтөлбөрийн үнэлгээ 0.928, оюутны оролцоо 0.899) тус тус өндөр утгатай гарсан нь эдгээр хэмжилтүүд маш найдвартайд тооцогдож байна.

Нийлмэл найдвартай байдлын хамгийн их утга мөн адил сургалтын чанар хувьсагчид 0.966-гаар илэрч, судалгааны гол үр дүнг тайлбарлах үндсэн хувьсагч хамгийн тогтвортой, бат бөх хэмжигдсэнийг нотолж байна. Үүний дараа сургуулийн орчин 0.951, сургалтын хөтөлбөрийн үнэлгээ 0.943, оюутны оролцоо 0.921 өндөр үзүүлэлттэй байна.

Дундаж хэлбэлзлийн хамгийн их утга нь мөн сургалтын чанар хувьсагчид 0.779 утгатай, сургалтын хөтөлбөрийн үнэлгээ 0.735, сургуулийн орчин 0.708, оюутны оролцоо 0.625 гэсэн дарааллаар өндөр байна гэж дүгнэж байна (загвар 02, хүснэгт 01).

Загвар 02. Сургалтын чанарыг үнэлгээний үр дүн (Cronbach's alpha)



Тайлбар. Pr.sk-Багшийн арга зүй; pr.tch-Багшийн заах арга; pr.sk-Багшийн мэргэжлийн ур чадвар; com.at-Багшийн харилцаа, хандлага; st.engt-Оюутны оролцоо; cuer.ev-Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ; envt-Сургуулийн орчин; EDU.QLT-СУРГАЛТЫН ЧАНАР

Хувьсагчид	Кронбах альфа	Нийлмэл найдвартай байдал	Дундаж хэлбэлзэл
Багшийн арга зүй	0.845	0.885	0.565
Багшийн заах арга	0.895	0.912	0.635
Багшийн мэргэжлийн ур чадвар	0.847	0.884	0.609
Багшийн харилцаа, хандлага	0.763	0.832	0.515
Оюутны оролцоо	0.899	0.921	0.625
СУРГАЛТЫН ЧАНАР	0.959	0.966	0.779
Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ	0.928	0.943	0.735
Сургуулийн орчин	0.940	0.951	0.708

Хүснэгт 01. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн

Тайлбар. Судалгааны ажлын боловсруулалт, үр дүн.

Хүчин зүйлийн хамаарлын шинжилгээг хийн үнэлэхэд хувьсагч бүрийн хамаарлын утга энгийн тоон утгаас өндөр гарсан нь хэмжилт хангагдсаныг харуулсан. Багшийн заах арга зүй 0.751 нь багшийн мэргэжлийн ур чадвартай 0.777, багшийн мэргэжлийн ур чадвар 0.780 нь сургуулийн орчинтой 0.802 харьцуулахад өндөр хамааралтай гарсан нь эдгээр хувьсагчид онолын хувьд хоорондоо нягт уялдаатай, утга агуулгын хувьд ойролцоо байж болохыг илтгэж байна. Сургалтын чанар нь хамгийн өндөр утга бүхий 0.883 утгатай гарсан нь бусад бүх хувьсагчаас

ялгарч, судалгааны үндсэн үр дүнгийн хувьсагч болохын хувьд бусдаас илүү сайн тодорхойлогдож байгааг харуулсан.

Бид судалгааны хэмжилтийн загвар дахь хувьсагч бүр өөр өөр ойлголтыг бодитой хэмжиж байгаа эсэхийг нотлох чухал аргын нэг Fornell-Larcker (ялгарах чадварыг шалгах арга) болон Heterotrait-Monotrait Ratio (хувьсагч хоорондын харьцангуй хамаарлын харьцаа)-гаар давхар шалгаж баталгаажуулсан. Ийнхүү шалгахад, бүх хувьсагч нь өөрийн үзүүлэлтүүдээрээ илүү сайн тайлбарлагдаж, бусад хувьсагчтай хэт давхардаагүй байгааг баталсан (хүснэгт 02).

Хүснэгт 02. Хамаарлын шинжилгээний үр дүн

Хувьсагчид	[1]	[2]	[3]	[4]	[5]	[6]	[7]	[8]	[9]
Багшийн арга зүй	0.751								
Багшийн заах арга	0.436	0.797							
Багшийн мэргэжлийн ур чадвар	0.777	0.540	0.780						
Багшийн харилцаа, хандлага	0.408	0.193	0.319	0.717					
Оюутны оролцоо	0.598	0.415	0.679	0.491	0.791				
СУРГАЛТЫН ЧАНАР	0.747	0.404	0.766	0.376	0.779	0.883			
Сургалтын	0.752	0.513	0.745	0.465	0.567	0.715	0.85		



МОНГОЛЫН
ХАМГААГАХ
МОНГОЛЫН
ХАМГААГАХ
МОНГОЛЫН
ХАМГААГАХ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХ
ХАМГААГАХ ЯАМ

хөтөлбөрийн үнэлгээ							7		
Сургуулийн орчин	0.720	0.442	0.802	0.660	0.662	0.684	0.722	0.841	
Удирдлагын дэмжлэг	0.638	0.466	0.776	0.363	0.660	0.752	0.723	0.181	0.859

Тайлбар. Судалгааны ажлын боловсруулалт, үр дүн.

Багшийн арга зүй – Сургалтын чанар ($\beta = 0.061$, $t = 0.424$, $p = 0.671$) р-үнэ 0.05-аас их тул багшийн арга зүй нь сургалтын чанарт статистикийн хувьд ач холбогдолтой нөлөө үзүүлээгүй, уг таамаглал батлагдаагүй гэж дүгнэж байна. Багшийн заах арга □ Сургалтын чанар ($\beta = 0.283$, $t = 1.990$, $p = 0.047$) р-үнэ 0.05-аас бага гарсан тул багшийн заах арга нь сургалтын чанарт эерэг, ач холбогдолтой нөлөө үзүүлсэн, уг таамаглал батлагдсан.

Багшийн мэргэжлийн ур чадвар □ Сургалтын чанар ($\beta = 0.022$, $t = 0.113$, $p = 0.910$) Энэ хувьсагчийн р-үнэ маш өндөр гарсан нь мэргэжлийн ур чадварын сургалтын чанарт үзүүлэх нөлөө статистикийн хувьд огт ач холбогдолгүй болохыг харуулж, таамаглал батлагдаагүй. Багшийн харилцаа, хандлага □ Сургалтын чанар ($\beta = 0.091$, $t = 0.795$, $p = 0.427$). Эдгээр үзүүлэлт нь сургалтын чанарт мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй, таамаглал батлагдаагүй.

Оюутны оролцоо □ Сургалтын чанар ($\beta = 0.487$, $t = 2.677$, $p = 0.008$) р-үнэ 0.01-ээс бага, эх утга хамгийн өндөр (0.487) гарсан тул оюутны оролцоо нь сургалтын чанарт хамгийн хүчтэй, статистикийн өндөр ач холбогдолтой нөлөө үзүүлсэн, уг таамаглал батлагдсан. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ □ Сургалтын чанар ($\beta = 0.176$, $t = 0.775$, $p = 0.439$) р-үнэ 0.05-аас их байгаа тул сургалтын хөтөлбөрийн үнэлгээ нь сургалтын чанарт ач холбогдолтой нөлөө үзүүлээгүй, таамаглал батлагдаагүй.

Сургуулийн орчин □ Сургалтын чанар ($\beta = 0.165$, $t = 1.116$, $p = 0.264$) тоон утга нөлөө сул бөгөөд статистикийн хувьд ач холбогдолгүй, таамаглал батлагдаагүй байна. Удирдлагын дэмжлэг □ Сургалтын чанар ($\beta = 0.294$, $t = 1.310$, $p = 0.191$) нь сургалтын чанарт эерэг чиглэлийн боловч статистикийн хувьд баталгаажаагүй нөлөөтэй, таамаглал мөн батлагдаагүй гэж дүгнэж байна.

Хүснэгт 03. Замын шинжилгээний үр дүн

ТААМАГЛАЛ	Эх утга	T Статистик	П үнэ цэнэ	ҮР ДҮН
Багшийн арга зүй- Сургалтын чанар	0.061	0.424	0.671	батлагдаагүй
Багшийн заах арга - Сургалтын чанар	0.283	1.990	0.047	батлагдсан
Багшийн мэргэжлийн ур чадвар- Сургалтын чанар	0.022	0.113	0.910	батлагдаагүй
Багшийн харилцаа, хандлага- Сургалтын чанар	0.091	0.795	0.427	батлагдаагүй
Оюутны оролцоо- Сургалтын чанар	0.487	2.677	0.008	батлагдсан
Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ- Сургалтын чанар	0.176	0.775	0.439	батлагдаагүй

Сургуулийн орчин-Сургалтын чанар	0.165	1.116	0.264	батлагдаагүй
Удирдлагын дэмжлэг-Сургалтын чанар	0.294	1.310	0.191	батлагдаагүй

Тайлбар. Судалгааны ажлын боловсруулалт, үр дүн.

Дөрөв. Дүгнэлт

Төгсөгчдийн үнэлгээнд тулгуурласан тоон болон чанарын шинжилгээний үр дүнгээс харахад сургалтын чанарт оюутны оролцоо болон багшийн заах арга нь статистикийн хувьд ач холбогдолтой, бодит нөлөө үзүүлж буй гол хүчин зүйлс болох нь тогтоогдсон. Багшийн арга зүй, мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлага, сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, сургуулийн орчин, удирдлагын дэмжлэг зэрэг үзүүлэлтүүд нь төгсөгчдийн үнэлгээгээр сургалтын чанарт шууд нөлөөлсөн гэж статистикийн хувьд батлагдаагүй.

Төгсөгчид сургалтын чанарыг үнэлэхдээ багшийн бодит заах үйл ажиллагаа, мөн суралцах үйл явц дахь өөрсдийн идэвх, оролцоог хамгийн чухал гэж үзэж байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, төгсөгчдийн хувьд сургалтын чанар нь орчны нөхцөл, бодлогын дэмжлэгээс илүүтэйгээр хичээлийн явц дахь суралцах туршлага, оролцоо, багшийн заах арга барилтай шууд холбоотой гэж дүгнэж болно.

Бид судалгааны ажлынхаа үр дүнгээс дараах хоёр саналыг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт, төгсөгчдийн дүн шинжилгээнд тулгуурлан их, дээд сургуулиуд оюутны оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хэлэлцүүлэгт суурилсан хичээл, багаар ажиллах даалгавар, бие даалт, судалгаанд суурилсан сургалтын аргуудыг системтэйгээр нэвтрүүлэх шаардлагатай байна.

Хоёрдугаарт, багшийн заах аргыг сайжруулах зорилгоор заах чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт, туршлага

солилцох хөтөлбөр, орчин үеийн сургалтын арга зүйг нэвтрүүлэх дотоод тогтолцоог тогтмол хэрэгжүүлэх нь зүйтэй. Ингэснээр төгсөгчдийн үнэлгээгээр илэрч буй сургалтын чанарын гол сул талуудыг багасгах, давуу талыг улам бэхжүүлэх боломж бүрдэнэ.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- [1]. World Bank. (2017). Higher education overview. World Bank Group.
- [2]. UNESCO. (2015). Education 2030: Incheon Declaration and Framework for Action. UNESCO Publishing.
- [3]. Altbach, P. G., Reisberg, L., & Rumbley, L. E. (2009). Trends in global higher education: Tracking an academic revolution. UNESCO.
- [4]. Trow, M. (1973). Problems in the transition from elite to mass higher education. Carnegie Commission on Higher Education.
- [5]. Harvey, L., & Green, D. (1993). Defining quality. Assessment & Evaluation in Higher Education, 18(1), 9–34.
<https://doi.org/10.1080/0260293930180102>
- [6]. Van Vught, F. A., & Westerheijden, D. F. (1994). Towards a general model of quality assessment in higher education. Higher Education, 28(3), 355–371.
<https://doi.org/10.1007/BF01383722>
- [7]. Sursock, A. (2011). Examining quality culture: Part II – Processes and tools. European University Association (EUA).
<https://eua.eu>
- [8]. Ryan, P. (2015). Quality assurance in higher education: A review of literature. Higher Learning Research Communications, 5(4), 1–15.



МОНГОЛЫН ХӨРӨНГӨ
УЛАМ
МОНГОЛ



אשר יבא אל ה' ויגיד לו כל אשר עשה לו

<https://doi.org/10.18870/hlrc.v5i4.257>

- [9]. Beerkens, M. (2015). Quality assurance in the higher education policy process: European and national policy dynamics. *Policy and Society*, 34(1), 57–67. <https://doi.org/10.1016/j.polsoc.2015.01.002>
- [10]. Delors, J. (1996). *Learning: The treasure within*. Paris: UNESCO Publishing.
- [11]. Dewey, J. (1938). *Experience and education*. New York, NY: Macmillan.
- [12]. Kolb, D. A. (1984). *Experience: Experience as the source of learning and development*. Englewood Cliffs, NJ: Prentice-Hall.
- [13]. Kolb, A. Y., & Kolb, D. A. (2005). *Learning styles and learning spaces: Enhancing experiential learning in higher education*. *Academy of Management Learning & Education*, 4(2), 193–212. <https://doi.org/10.5465/amle.2005.17268566>
- [14]. Dill, D. D. (2007). Quality assurance in higher education: Practices and issues. In G. R. Jones, *Encyclopedia of Higher Education* (pp. 283–293). Elsevier.
- [15]. Woodhouse, D. (1999). Quality and quality assurance. In H. de Wit & J. Knight (Eds.), *Quality and internationalization in higher education* (pp. 29–44). OECD Publishing.